



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/98

Жаргалант

Бэлчээрийг түр чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ, байршил, зориулалтын жагсаалт батлах тухай” 136 тоот тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны “Норовлин сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө батлах тухай” 01 тоот тогтоолын 01 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Бэлчээрийн газрын хөрсийг нөхөн сэргээх, бэлчээрийг сайжруулах, доройтсон бэлчээрийг амраах, сэлгэх зорилгоор Ангирт багт 12102,7 га, Онон багт 6920,6 га, Баян-Өлзийт багт 3914,9 га бэлчээрийг 2025 оны 06 дугаар сарын 27-ний өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 20-ыг хүртэл малын хөлөөс түр хугацаагаар чөлөөлсүгэй.

2.Өнжөөж амраах, чөлөөлөх газрын байршил хилийн зургийг хавсралтаар батасугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж тогтоосон хугацаанд бэлчээрийг малын хөлөөс түр хугацаагаар чөлөөлөх ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, багийн Засаг дарга нарыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг, Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн (М.Мөнгөнтуяа), Байгаль Орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Баярмагнай), газрын даамалыг түр орлон гүйцэтгэгч (Г.Банзрагч) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501223

Сумын Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын
27-ны өдрийн А/28 тоот захирамжийн хавсралт



ӨНЖӨӨЖ АМРААХ, СЭЛГЭХ БЭЛЧЭЭРИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Багийн нэр	Газрын нэр	Хэмжээ /га/
1	Баян-Өлзийт	Цагаан нуурын баруун, Түмэнхааны урд энгэр, Рашааны баруун тал	3914,9
2	Ангирт	Ангиртын хоолой, Таван толгой, Улаан өндрийн баруун хоолой	12102,7
3	Онон	Улзын голын эх, Модны булаг, Авшиг овоо, Хар тогоот, Баруун, Зүүн, Дунд цагаан хошуу	6920,6
4	НИЙТ		22938,2